

## 155 ЯЛАЛТ, АМЖИЛТААР БАХАРХАХ

## 155.1 ЯМАР ХҮЧ, МӨНГӨ ЭСВЭЛ БУРХАНААР

Мөнгөөр олсон амжилт бол таны ажил; Бурханы хүчээр ирсэн амжилт бол - Түүний ажил юм. Мөнгөөр бүтээсэн амжилтын алдар нэрийг та хүлээн авах болно. Өөрийн хүчээр хийсэн ажлынхаа алдар сууг Бурхан хүлээн авах болно. Та хэнд алдрыг өгөх гэж байна вэ? Юу тарьсанаа хураана гэсэн хуулийг санаарай. Чиглэл, стратегиэ олж , зорилгоо Ариун Сүнс, Үг дотор итгэлээр гүйцэлдүүл.

Мөнгөөр хийдэг дэлхийн амжилт мөхдөг, харин та Бурханы хүчээр дэлхий дээр болон диваажинд амжилт олох болно. Бурханаас өгсөн хүчээр бүтээсэн ажил. Та ямар хүчээр ажилладаг вэ? Та ямар хүчээр амжилтанд хүрэхийг оролдож байна вэ? Аялалынхаа бариа дөхөх тусам магтаал болон талархалтайгаар зорилгодоо хүрээрэй. Найдвараа бүү алдаарай.

Эдгээрийг шалгана уу: Би биширч, итгэж байсан уу? Би дуулгавартай байсан уу? Би цаг үрсэн үү? Би хуваалцсан уу? Би хайрын үүднээс үйлдсэн үү?

Бурхан тэр өдөр асуухад Бурханд хариулахад бэлэн байгаарай. Тэр дуудсан, томилсон бөгөөд итгэлтэй байх нь бидний хариуцлага юм.

## 155.2 БУРХАН ХЭЗЭЭ Ч ӨӨРЧЛӨГДӨГГҮЙ, ТЭРЭЭР АМЛАСНАА БИЕЛҮҮЛДЭГ

Бурхан худал хэлдэггүй, өөрчлөгддөггүй. Өөрт нь итгэвэл Христ дотор Бурханы бүх амлалт БИЕЛДЭГ. Тэр ганцаараа итгэмжит бөгөөд Христ дотор итгэлээр асуусан бүхэнд хариулдаг.

Цаг хугацааны шинж тэмдгүүдийг мэдэх. Сэрэмжтэй , бэлэн байгтун.

- а) Христийг дахин ирэх үеийн цаг хугацаанд амьдарч байгаа үеийнхэн нь хамгийн ерөөлтэй юм.
- б) “ Ноагийн өдрүүдийнх шиг” гэсэн Үг нь ямар утгатай болохыг тунгаан бясалгаж мэдэх
- в) Иерусалим дахь сүм баригдаж байгааг сонсвол тэрхүү цаг айсуйг мэдэх болно
- г) Антихрист нь нийтэд ил болно. Дэлхийн асуудлыг шийдвэрлэж байгаа мэтээр хүлээн зөвшөөрөгдөх нэгэнийг анзаарах
- д) Хуурамч эш үзүүлэгчид гарч ирж Түүний дахин ирэлтийг тунхаглах болно. Яагаад? Муу нэгэн нь Бурханы хүмүүсийг төрөлдүүлж самууруулахыг хүсдэг.
- е ) Түүний дахин ирэлтийн өмнө үлэмж зовлон хэцүү цаг бий болно. Энэ нь бэлэн байгаа хүмүүсийн хувьд сайн зүйл юм.

### 155.3 ТИЙМ/ ҮГҮЙ ХАРИУЛТ

Тэр өдөр Бурхан асуухад та “ТИЙМ эсвэл ҮГҮЙ” гэх болно. Шалтаг хэлэх боломжгүй. Завсрын хариулт гэж байхгүй бөгөөд энэ зөвхөн шалтаг юм. Шүүлтийн Өдөр завсрын байрлал гэж байхгүй. Та энд шалтаг тоочих ч цорын ганц Хүү Есүс Христээ илгээсэн Бурханы оршихуйд тэр нь боломжгүй юм. Та ганцаараа зогсоод ганцаараа хариулах болно.

Таны намтар түүхэнд юу бичигдсэн бэ? Энэ дэлхий дээр болон диваажин дахь хийсэн зүйлээр Бурхан таныг шүүх болно. “ТИЙМ эсвэл ҮГҮЙ” гэж хариулахад л бэлтгэгтүн. Дагалдагчдыг дуудаж ил болго. Зайлсхийн чимээгүй байгаа хүмүүсийн хувьд ялалт ч амжилт ч аль аль нь байхгүй болно. Бурханы хүсэл ба төлөвлөгөөг үл ойшоодог амжилт ба ялалт нь удахгүй мөхөх Содом Гоморраг барьж босгож байгаатай адил юм.

### 155.4 ИОШУАД СТРАТЕГИ, ХАРИУЛТТАЙ ЗАЛБИРАЛ БАЙСАН

Ухаалаг байж боломжийг бүү алд, тэрхүү зөв цагийг бүү алд, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх стратегитэй бай. Залбираад бизнес эхлэх хүнийг олоод бизнес эхлүүл. Иошуа стратеги болон хариулттай залбиралтай ажиллахаар явсныг санагтун.

## **155.5 ТОДОРХОЙ ЗОРИЛГО БИЧИЖ, ЦАГ УЛИРЛЫГ НЬ МЭДЭГТҮН**

Тодорхой зорилгуудыг бич. Алсын хараагаа ухаалаг зөвлөгөөгөөр нарийвчлан бич. Их Эзэнтэй ямагт зөвлөлд. Залбирлаар дамжуулан төлөвлөгөө гаргаж Түүний хариултыг хүлээ. Хэнийг алдаршуулж байгааг ямагт шалга. Өргөнөөр сэтгэ.

Эрэмбэлэх жагсаалтыг ганцаараа бүү гарга. Амьдралын үндсэн хэрэгцээг цөлд ч Бурхан бэлтгэсэн (хоол хүнс, хувцас, байр) талаар санаад юу хийж чадахаа эхлээд хий.

- а ) Үйлдэх цаг хугацаагаа ялган тань
- б ) Аливаа төлөвлөгөөг гаргахдаа мэргэжлийн зөвлөгөө авч судалгаа хий
- в ) Нарийвчилсан төлөвлөгөө гарга
- г ) Төлөвлөгөөгөө нэг хуудсанд багтааж нэгтгэх
- д ) Зөв хүмүүсийг яаж хэрхэн танихыг мэдэх
- е ) Бүх зүйлийг залбирлаар дамжуулан Эзэнтэй хэлэлц
- ё ) Бүх зүйлийг залбирлаар бэлдэж хариултыг нь хүлээ
- ж ) Энэ нь хэний алдрын төлөө: хэний хүчээр вэ гэдгийг бод
- з ) ”Өглөөний шүүдэр” дагалдагчдыг бэлдэх тал дээр төвлөрөх
- к ) Гуйлгачин, өнчин, өвчтэй хүмүүс байдаг гэдгийг анхаар
- л ) Чөлөөтэй сэтгэн бод. Бурханыг өөрийн бодлоор бүү хязгаарла
- м ) Үйлдлээ өөрөө бүү чухалчил

н ) Боломжтой бөгөөд нээлттэй зүйлээс эхэл

о ) Цөлд ч Бурхан үндсэн хэрэгцээг хангаж байсныг сана

Бурханы Үгэнд үндэслээгүй аливаа зүйл нь цаг хугацааг дэмий үрж байгаа хэрэг бөгөөд цаг хугацаа өнгөрөхөд үндсээрээ зулгаагдах болно. Бурханы Үгэн дээр баригдаагүй ажил үйлс, амжилтууд нь муу нэгэний эрхшээлд байх болно.

### 155.6 АМИЛСАН ХРИСТИЙГ ДАГАХ

Өнөөдөр Сатан биш Амилсан Христ Өөрийн Үгээр дэлхийг барьж байна. Тэрээр итгэгчидийн зүрх сэтгэлд оршихын тулд Ариун Сүнсийг бэлэглэсэн. Түүний нэрийг алдаршуул, Түүний далбаануудыг өргө!

Та нар амилсан Христийг дагахад,

Гэрэл гэгээ ирж, харанхуй алга болж,

Харанхуй -тал биш гэрэл нь ноёлж

Гэрэл асаж, харанхуй тал нь нуран унаж,

Үхэгсэд амийн сүнс дотор босдог

Миний дотор зөв шударга сүнс оргилж

Энэ нь амьдралыг авчирч, алдагдсан мөрөөдлийг сэргээдэг

Бүх зүйлийг Их Эзэний баяр баясгаланд буцаан сэргээ.

Бабелын Цамхаг шиг нурж унах зүйлийг бүү барь. Ийм ажлын үр дүн нь амилсан Аврагчийн төлөө биш гэдгийг бодож үзээрэй.

" Христ намайг юуны төлөө тогтоон барьсан тэр зүйлээс зуурах" гэдэг нь юу гэсэн үг вэ? "Хэвийн амьдрал", "хэвийн мөргөл", "хэвийн нөхөрлөл" зэрэгтэй байж "хэвийн итгэгч" болох гэдэг нь Христийн золиослолоор дамжуулан аль хэдийн олж авсан зүйлээсээ зуурах гэсэн үг юм. Талархсан зүрх сэтгэлээр Христийг " Рабби" хэмээн хүлээн зөвшөөрөх үед таны талархсан зүрх сүнсийг тань нээж, Христийн хайрыг хүлээн

авсан. Ариун Сүнснийхээс бусдаар хэн ч Есүсийг Христ гэж таниж чадахгүй. Та ийнхүү зөвшөөрсөн бол Бурханаас төрж ерөөлийн зам дээр гарч ирсэн юм.

### 155.7 ХҮЛЭЭН АВ, ЗОХИЦУУЛ МӨН БАЯРЛА

Ялалт, амжилтыг ялган таньж, Их Эзэнээс ирдэг ерөөлүүдийг хүлээн ав. Хүлээн авсан зүйлүүдээ сайн зохицуулан тэдгээрийг таашаа. Ялалт нь хэнээс, юуны төлөө ирдэг вэ? Төлөвлөгөө бүрээ Бурханы Үг дээр зохио.

Итгэлийн уралдаанд гүйнэ гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ нь бариа хүртэл гүйх гэсэн үг юм. Итгэлийн уралдаанд тэтгэвэрт гарна гэж байхгүй. Бурханаас титмээ хүлээн авах хүртлээ гүйдэг. Бид итгэлтэй хүн болох ёстой. Учир нь итгэл бол бүх ерөөлийн цорын ганц суваг юм.

Итгэл бол Бурханаас ирсэн агуу бэлэг. Итгэлийн энэ бэлэг бидэнд хэрхэн ирдэг вэ? Бурханы Үгийг сонссоноор итгэл төрдөг. Янз бүрийн хүмүүс, хэл соёл, шашин нөхцөл байдалд сайн мэдээг цэврээр нь дамжуулах тохирох зэвсэг бидэнд байна уу?